МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 01 өдөр Дугаар А/26 Мөрөн сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээг
шилжүүлэн эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2, 38 дугаар зүйлийн 38.1, 38.2, 38.4, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2, Хөвсгөл аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 16 дугаар шийдвэр, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөл аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 16 дугаар шийдвэрээр "гуравдагч этгээд Г.Цэдэндамбын Хөвсгөл аймгийн Засаг даргад холбогдуулан гаргасан бие даасан шаардлагыг бүхэлд нь хангаж, Б.Лхамсүрэн агсны газар эзэмших эрхийн анхдагч гэрээнд заасан газар эзэмших хугацаа дуустал өвлөгч Г.Цэдэндамбад газрыг үргэлжлүүлэн эзэмшүүлэх шийдвэр гаргахыг Хөвсгөл аймгийн Засаг даргад даалгаж, Б.Лхамсүрэн агсны өв залгамжлагч Г.Цэдэндамбатай газар эзэмших эрхийн гэрээ шинэчлэн байгуулж, газар эзэмших эрхийн гэрчилгээг шинэчлэн олгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт даалгаж, Мөрөн сумын Засаг даргын 2006 оны 90 дүгээр захирамжийн 2 дугаар хавсралтын 7-д бичигдсэн газар эзэмшигч Б.Лхамсүрэнд холбогдох хэсгийн газрын хэмжээ, газар эзэмших хугацааг засварласныг ил хууль бус болохыг тогтоож" шийдвэрлэсний дагуу Мөрөн сумын 8 дугаар баг 9-49 тоотод байршилтай 6712017170 нэгж талбарын дугаар бүхий амины хашааны зориулалттай 3050м^2 газрын газар эзэмшигч иргэн Бадрах овогтой Лхамсүрэн (РЮ49050111)-ийн газар эзэмших эрхийг 2016 оны 02 дугаар сарын 19-ны өдрийн №015 дугаартай өвлөх эрхийн гэрчилгээг үндэслэн газар өвлөх эрх хүлээн авагч Гомбосүрэн овогтой Цэдэндамба (РЮ53101707)-д амины хашааны зориулалттай гэснийг газрын нэгдмэл сангийн газар ашиглалтын зориулалтад тохируулан гэр орон сууцны хашааны газар гэж өөрчлөн газар эзэмших хугацааг үлдсэн 23 жилийн хугацаатайгаар шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Уг захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 04-ны өдрийн А/108 дугаар захирамжийн хавсралтын 3 дахь заалтыг хүчингүй болгосугай.

3. Шинээр газар эзэмшиж байгаа иргэн Г.Цэдэндамбатай газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Мөнгөнзул)-т тус тус зөвшөөрсүгэй.

4. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт

6712010196

хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг)-т үүрэг болгосугай.

5. Аймгийн Засаг даргын захирамжийг эс зөвшөөрвөл захирамжийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (М.Алтаншагай)-д үүрэг болгосугай.

ДАРГА Ш.ИДЭРБАЯСГАЛАН